

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ОРОН НУТГИЙН НЭГЖИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь орон нутаг дахь худалдан авах ажиллагааны нэгжийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгж нь орон нутаг дахь худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг эрхлэхийн зэрэгцээ худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, орон нутгийн удирдлагыг мэдээллээр хангаж, зөвлөгөө өгч ажиллана.

1.3. Орон нутгийн нэгж нь энэ журам болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хүрээнд ажиллана.

Хоёр. Орон нутгийн нэгжийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгж нь аймаг, нийслэл, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгжээс бүрдэнэ.

2.2. Аймаг, нийслэл, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгж нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-т заасан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгж \цаашид “орон нутгийн нэгж” гэх\ байна.

2.3. Аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны нэгж нь худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын, дүүргийн худалдан авах ажиллагааны нэгж нь нийслэлийн худалдан авах ажиллагааны нэгжийн удирдлага дор тус тус ажиллана.

2.4. Орон нутгийн нэгжийн бүтцийг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн, батлагдсан төсөв, орон тооны хүрээнд бүрдүүлэн ажиллана.

2.5. Аймаг, нийслэл дэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын дарга, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг нийслэл дэх худалдан авах худалдан авах ажиллагааны нэгжийн дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн тус тус томилж, чөлөөлнө.

2.6. Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжийн дарга нь ял шийтгэлгүй, төрийн албанд 5-аас доошгүй жил, үүнээс худалдан авах ажиллагааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байна.

2.7. Орон нутгийн нэгжийн дарга нь тухайн шатны Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана.

Гурав. Орон нутгийн нэгжийн хэрэгжүүлэх чиг үүрэг, бүрэн эрх

3.1. Орон нутгийн нэгж нь орон нутагт хэрэгжих худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Тухайн орон нутагт хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны сар, улирал, жилийн төлөвлөгөө, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

3.1.2. Худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлэх;

3.1.3. Иргэд, аж ахуй нэгж болон тендерт оролцогчдыг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт сурталчилгаа зохион байгуулах;

3.1.4. Худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд мэдээлэх;

3.1.5. Худалдан авах ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагч, албан тушаалтан, түүнчлэн аж ахуй нэгжүүд хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасан тухай бүр нотлох баримтын хамтаар холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;

3.1.6. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхээр гэрээ байгуулсан, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуй нэгжүүдийн зөрчлийг бүртгэн авч, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулахаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал хүргүүлэх;

3.1.7. Ерөнхий гэрээ байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.8. Төрийн захиргааны төв болон худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах, уялдаа холбоог сайжруулах;

3.1.9. Хуульд заасан бусад чиг үүрэг.

Дөрөв. Орон нутгийн нэгж худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх

4.1. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгж нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-т заасан жагсаалт батлагдсаны дараа мөн хуулийн 47 дугаар зүйл болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг үндэслэн үнэлгээний хороо байгуулна.

4.2. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд захиалагч, тухайн салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, орон нутагт иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон төлөөллийг оролцуулна.

4.3. Үнэлгээний хорооны гишүүд нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

4.4. Үнэлгээний хороонд орж ажиллах гишүүнээр “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг тухай бүр бөглүүлж, худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээтэй эсэхийг нягталж үзнэ.

4.5. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгж нь худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа тендер шалгаруулалтын материалыг хуулийн 49.2 дэх хэсэгт заасны дагуу архивын нэгж болгон хадгална.

4.6. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулсан тохиолдолд энэхүү журмын 4.5-д заасны дагуу холбогдох материалыг архивлахдаа хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.3, 49.2.5-д заасан материалыг цахим хэлбэр /CD, DVD дээр буулган/-ээр архивын нэгж үүсгэж, хадгална.

Тав. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд тавих хяналт

5.1. Орон нутгийн нэгж нь гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт тавьж, сар тутам мэдээ, тайлан гаргана.

5.2. Энэхүү журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасан мэдээ, тайланг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад сар тутамд хүргүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

Зургаа. Гомдол маргаан шийдвэрлэх

6.1. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн хууль бус шийдвэр, гомдол, хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.

6.2. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 6 дугаар зүйлийн 6.1-д заасан хууль бус шийдвэр, гомдлыг хянан үзэхдээ тухайн хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, татан авах, өөрчлөх эрхтэй.

6.3. Өргөдөл, гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан хугацааг баримтална.